



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 489

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь заалт, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.4 дэх заалт, 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.2.5, 6.4.3, 6.4.6, 6.5, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй нь Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагчийн 2018 оны 02-07-094/636 дугаар актаар тогтоогдсон, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 3 нэрийн, нийт 7,958,080.00 (долоон сая есөн зуун тавин найман мянга наян) төгрөгийн балансын үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгө (барилга байгууламж, бусад хөрөнгө)-ийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 4 нэрийн, нийт 48,725,000.00 (дөчин найман сая долоон зуун хорин таван мянган) төгрөгийн балансын үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгө (автомашин)-ийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Билгүүн, Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

3.2. Үл хөдлөх хөрөнгийн газар /чөлөөлөгдөх талбай/-ыг төрийн байгууллагын эзэмшилд хэвээр үлдээж, албан ажлын зориулалтаас өөрөөр ашиглахгүй байх, газрыг нөхөн сэргээх;

3.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.4.Сэлбэгээр худалдсан автотээврийн хэрэгслийн улсын бүртгэл болон татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах, арга хэмжээний биелэлтийг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн
489 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬАА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Хэмжих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
Нэг. Тээврийн цагдаагийн албаны Төмөр зам дахь Цагдаагийн газар						
1.1 Авто тээврийн хэрэгсэл						
1	Мотоцикль /DY-150A Dayun/	2012.01.10	1,350,000.00	ширхэг	4	5,400,000.0
	Дүн					5,400,000.00
1.2 Бусад үндсэн хөрөнгө						
1	Чиргүүл /цогцосны/	2001.01.01	550,000.00	ширхэг	1	550,000.00
	Дүн					550,000.00
Хоёр. Сургалтын нэгдсэн төв						
2.1 Барилга байгууламж						
1	Зуслангийн соёлын төв	1980.05.15	2,008,080.00	ширхэг	1	2,008,080.00
	Дүн					2,008,080.00
	Нийт дүн					7,958,080.00 (долоон сая есөн зуун тавин найман мянга наян)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08 ны өдрийн
489 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ (АВТОМАШИН)-ИЙН
ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтанд орсон он	Нийт гүйлт (км)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэлбэгээр худалдсанаас олох орлогын доод хэмжээ үнэ (төгрөг)
Нэг.Сүүж-Уул амралт сэргээн засах сувилал					
1	Бонго, 13-51 УНУ /хөргүүртэй машин/ Дүн	12/31/2013	187428	23,100,000.00 23,100,000.00	500,000.00 500,000.00
Хоёр. Автобааз					
2	Мицубиши делика, 94-98 УБН /арал-pe8w0028519/	2005.12.29	477481	6,125,000.00	500,000.00
3	Киа рио 03-74 УНУ /knadm412ad6271912/	2013.08.08	196145	18,000,000.00	250,000.00
4	Хьюндай соната 57-69 УБЗ /арал-kmhem41bp1a532794/	2018.09.05	195011	1,500,000.00	300,000.00
	Дүн			25,625,000.00	1,050,000.00
	Нийт дүн			48,725,000.00 (дөчин найман сая долоон зуун хорин таван мянган)	1,550,000.00 (нэг сая таван зуун тавин мянган)